

НИЙСЛЭЛИЙН ОРОН СУУЦНЫ БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны сарын -ны өдөр

Дугаар /

Улаанбаатар хот

Албан хаагчдын гүйцэтгэлийн
төлөвлөгөөний биелэлтийг үнэлэх Үнэлгээний
багийн бүрэлдэхүүн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны “Журам шинэчлэн батлах тухай” 301 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын 6 дугаар зүйлийн 6.1, 6.3 дахь хэсэг, 2023 оны “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 442 дугаар тогтоол, Нийслэлийн Орон сууцны бодлогын газрын дүрмийн 7.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Албан хаагчдын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлэх, хянаж баталгаажуулах, мэдээлэх чиг үүрэг бүхий Үнэлгээний багийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:	Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга
Гишүүд:	Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга
	Орон сууцны дэд бүтцийн хэлтсийн дарга
	Төслийн зохицуулалтын хэлтсийн дарга
	Дотоод хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн

Нарийн бичиг: Хүний нөөц, сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн

2. Албан хаагчдын гүйцэтгэлийн үнэлгээний ангиллыг харгалзан олгох мөнгөн урамшууллын хэмжээг хавсралтаар баталсугай.

3.Албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэжлийн түвшинг холбогдох журмын дагуу үнэлж, 2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн үнэлгээг 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор, сүүлийн хагас жилийн үнэлгээг 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор баталгаажуулж тайлагнахыг Үнэлгээний багт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.БОЛОРТУЯА

Боловсруулсан:Хүний нөөц, сургалт
хариуцсан ахлах мэргэжилтэн

Б.Энхзаяа

Нийслэлийн Орон сууцны бодлогын газрын
даргын 2024 оны дугаар сарын-ны
өдрийн дугаар тушаалын хавсралт

Гүйцэтгэлийн үнэлгээний ангиллыг харгалзан
албан хаагчдад олгох мөнгөн урамшууллын хэмжээ

Д/д	Үнэлгээний ангилал	Оноо	Улирлын ажлын мөнгөн урамшууллын хэмжээ
1	“Маш сайн”	85-100	Үндсэн цалингийн 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн дүн
2	“Хэвийн”	70-85	Үндсэн цалингийн 25 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн дүн

